



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/73/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483034	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484030	Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор: Ж.Бүжинханд	
Утас: 99177546	Цахим хаяг: Buujinkhandj@audit.gov.mn	
Аудитор	Г.Энхдэлгэр	
Утас: 70484030	Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.ГАНБОЛД ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 54
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020323

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,067,560.00	18,449,350.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	27,067,560.00	18,449,350.00
354	Хангамжийн материал	27,067,560.00	18,449,350.00
35410	Бичиг хэргийн материал	4,005,970.00	1,355,800.00
35420	Аж ахуйн материал	16,389,590.00	16,666,550.00
35440	Түлш, шатах тослох материал	6,672,000.00	427,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	793,542,837.90	826,584,944.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	793,542,837.90	826,584,944.38
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	768,667,087.88	802,096,694.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	652,904,660.00	652,904,660.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,916,556.88)	(59,874,835.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,012,000.00	87,312,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(9,809,333.34)	(17,348,666.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	159,407,310.50	140,200,781.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(80,655,554.37)	(52,482,949.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,476,952.43	71,539,352.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,081,804.12)	(39,799,849.10)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,606,106.50	19,606,106.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,932,489.84)	(2,898,734.76)
39217	Ном	2,655,797.00	2,938,829.00
393	Биет бус хөрөнгө	24,875,750.02	24,488,250.10
39301	Програм хангамж	1,550,000.00	1,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(106,249.98)	(493,749.90)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	820,610,397.90	845,034,294.38
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	114,204.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	114,204.00	-
413	Өглөг	114,204.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	114,204.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	820,496,193.90	845,034,294.38
51	Засгийн газрын хувь оролцоо	820,496,193.90	845,034,294.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	505,963,683.00	505,963,683.00
51101	Өмч: - төрийн	505,963,683.00	505,963,683.00
512	Хуримтлагдсан үр дүн	(97,395,802.25)	(72,857,701.77)
51210	Өмнөх үеийн үр дүн	(97,395,802.25)	(97,395,802.25)
51220	Тайлант үеийн үр дүн	-	24,538,100.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	411,928,313.15	411,928,313.15
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	820,610,397.90	845,034,294.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,129,422,111.05	1,114,314,515.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,546,311.05	89,332,515.00
120	Нийтлэг татварын бус орлого	94,546,311.05	89,332,515.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө	20,176,440.00	80,175,759.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал	5,813,220.00	365,456.00
120009	Бусад орлого	68,556,651.05	8,791,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,034,875,800.00	1,024,982,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,026,375,800.00	1,024,982,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,026,375,800.00	1,024,982,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,500,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХ-хөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,076,997,790.12	1,089,776,414.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,076,997,790.12	1,089,776,414.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,052,877,914.12	1,082,750,202.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,637,204.00	772,374,503.00
210101	Үндсэн цалин	607,368,204.00	617,439,619.00
210102	Нэмэгдэл	110,275,900.00	114,416,929.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,832,701.00	23,451,676.00
210104	Урамшуулал	14,160,399.00	17,066,279.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,640,319.00	102,019,302.04
210201	Тэтгэврийн даатгал	64,380,619.00	71,334,498.21
210202	Тэтгэмжийн даатгал	7,564,900.00	7,744,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,051,900.00	6,223,903.01
210204	Ажилгүйдлийн даатгал	1,513,000.00	1,556,100.82
210205	Эрүүл мэндийн даатгал	15,129,900.00	15,159,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,280,663.00	49,187,887.72
210301	Гэрэл, цахилгаан	4,834,846.00	4,743,503.23
210302	Түлш, халаалт	37,969,485.00	42,825,272.49
210303	Цэвэр, бохир ус	1,476,332.00	1,619,112.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,268,916.00	43,647,219.50
210401	Бичиг хэрэг	20,725,264.00	13,860,626.00
210402	Тээвэр, шатахуун	13,586,000.00	11,960,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,869,502.00	9,132,303.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,291,150.00	5,558,050.00
210408	Бараа материал акталсны зардал	2,197,000.00	2,536,240.00
2105	Нормативт зардал	800,000.00	798,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	798,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,000,000.00	27,510,500.00
210604	Урсгал засвар	36,000,000.00	27,510,500.00
2107	Томилголт, зочны зардал	19,284,200.00	8,776,200.00
210702	Дотоод албан томилолт	14,284,200.00	8,776,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,226,396.00	4,511,638.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,984,876.00	3,254,502.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,078,000.00	1,078,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	72,640.00	88,256.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	46,880.00	46,880.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,740,216.12	73,924,952.52
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,740,216.12	73,924,952.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,119,876.00	7,026,211.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,500,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,500,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,619,876.00	5,026,211.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,619,876.00	5,026,211.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	52,424,320.93	24,538,100.48
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	52,424,320.93	24,538,100.48

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,963,683.00	412,406,884.30	(150,298,694.33)	768,071,872.97
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	478,571.15	478,571.15
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,963,683.00	412,406,884.30	(149,820,123.18)	768,550,444.12
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(478,571.15)	-	(478,571.15)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	52,424,320.93	52,424,320.93
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,963,683.00	411,928,313.15	(97,395,802.25)	820,496,193.90
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	505,963,683.00	411,928,313.15	(97,395,802.25)	820,496,193.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	505,963,683.00	411,928,313.15	(97,395,802.25)	820,496,193.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	24,538,100.48	24,538,100.48
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	505,963,683.00	411,928,313.15	(72,857,701.77)	845,034,294.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,034,875,800.00	1,024,982,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,034,875,800.00	1,024,982,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,026,375,800.00	1,024,982,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,026,375,800.00	1,024,982,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,500,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,016,291,300.00	1,006,982,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,016,291,300.00	1,006,982,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	992,171,424.00	999,955,788.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	755,523,000.00	772,488,707.00
210101	Үндсэн цалин	607,254,000.00	617,553,823.00
210102	Нэмэгдэл	110,275,900.00	114,416,929.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,832,701.00	23,451,676.00
210104	Урамшуулал	14,160,399.00	17,066,279.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шилжлэл	94,640,319.00	102,019,302.04
210201	Тэтгэврийн даатгал	64,380,619.00	71,334,498.21
210202	Тэтгэмжийн даатгал	7,564,900.00	7,744,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,051,900.00	6,223,903.01
210204	Ажилгүйдлийн даатгал	1,513,000.00	1,556,100.82
210205	Эрүүл мэндийн даатгал	15,129,900.00	15,159,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,280,663.00	49,187,887.72
210301	Гэрэл, цахилгаан	4,834,846.00	4,743,503.23
210302	Түлш, халаалт	37,969,485.00	42,825,272.49
210303	Цэвэр, бохир ус	1,476,332.00	1,619,112.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,001,846.00	32,075,553.50
210401	Бичиг хэрэг	16,740,394.00	11,233,200.00
210402	Тээвэр, шатахуун	5,984,000.00	5,715,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,869,502.00	9,132,303.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,807,950.00	5,395,050.00
2105	Нормативт зардал	800,000.00	798,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	798,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,415,000.00	30,098,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	415,000.00	-
210604	Урсгал засвар	36,000,000.00	30,098,500.00
2107	Томилолт, зочны зардал	19,284,200.00	8,776,200.00
210702	Дотоод албан томилолт	14,284,200.00	8,776,200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,226,396.00	4,511,638.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,984,876.00	3,254,502.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,078,000.00	1,078,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	72,640.00	88,256.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	46,880.00	46,880.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,119,876.00	7,026,211.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,500,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,500,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,619,876.00	5,026,211.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,619,376.00	5,026,211.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	18,584,500.00	18,000,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	18,584,500.00	18,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,584,500.00	18,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	18,584,500.00	18,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,584,500.00	18,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(18,584,500.00)	(18,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл
		Батлагдсан төлөвлөгөө	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,024,982,000.0	1,019,955,788.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,024,982,000.0	1,019,955,788.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,022,982,000.0	1,017,955,788.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	772,493,600.0	772,488,707.00
210101	Үндсэн цалин	623,235,600.0	617,553,823.00
210102	Нэмэгдэл	110,275,900.0	114,416,929.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,821,700.0	23,451,676.00
210104	Урамшуулал	14,160,400.0	17,066,279.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,526,600.0	102,019,302.04
210201	Тэтгэврийн даатгал	73,566,900.0	71,334,498.21
210202	Тэтгэмжийн даатгал	7,744,900.0	7,744,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,401,900.0	6,223,903.01
210204	Ажилгүйдлийн даатгал	1,653,000.0	1,556,100.82
210205	Эрүүл мэндийн даатгал	15,159,900.0	15,159,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,073,500.0	49,187,887.72
210301	Гэрэл, цахилгаан	5,579,800.0	4,743,503.23
210302	Түлш, халаалт	43,075,800.0	42,825,272.49
210303	Цэвэр, бохир ус	1,417,900.0	1,619,112.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,441,800.0	32,075,553.50
210401	Бичиг хэрэг	11,234,000.0	11,233,200.00
210402	Тээвэр, шатахуун	5,715,000.0	5,715,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,492,800.0	9,132,303.50
210405	Хог хаягдал зайлуулах, хорт он мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.0	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,400,000.0	5,395,050.00
2105	Нормативт зардал	800,000.0	798,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.0	798,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,100,000.0	48,098,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.0	18,000,000.00
210604	Урсгал засвар	30,100,000.0	30,098,500.00
2107	Томиллолт, зочны зардал	8,784,300.0	8,776,200.00
210702	Дотоод албан томилолт	8,784,300.0	8,776,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа	4,762,200.0	4,511,638.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,484,900.0	3,254,502.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,078,000.0	1,078,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,700.0	88,256.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.0	44,000.00
210807	Газрын төлбөр	55,600.0	46,880.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.0	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.0	2,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,024,982,000.0	1,019,955,788.26
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,024,982,000.0	1,019,955,788.26
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,024,982,000.0	1,019,955,788.26
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газар нь шүүн таслах үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүрэгтэй Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,075.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 21.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 17.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2 хувиар буюу 24.4 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18.4 сая төгрөг болж 8.6 сая төгрөгөөр буурсан нь түлш шатах тослох материалын зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 46.0 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 55.0 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 18.4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 999.5 сая төгрөг болж 21.4 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 26.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 80.2 сая төгрөгийн үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Тайлант онд 85.5 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 999.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 0.1 сая төгрөг байсныг тайлант онд барагдуулж, өр төлбөрийн үлдэгдэлгүй болсон.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 845.0 сая төгрөг болж 24.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл (72.9) сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,025.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 6 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,025.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,025.0 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,020.0 сая төгрөгийг зарцуулж 5.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,020.0 сая төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2.5 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1.4 сая төгрөгөөр, тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын санхүүгийн тайлан болон татварын цахим систем дэх татварын өглөг, авлагын тооцооллыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 2 байна.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 30.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй урсгал засварын зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 25.8 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар босго үнээс давсан төсөвт өртөгтэй худалдан авалтанд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байдлыг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 148.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 118.1 сая төгрөгийн алдааг залруулж, 30.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад тайлант хугацаанд 5.1 сая төгрөгийн гүйлгээнд төлбөрийн баримт аваагүй байсныг нөхөж и баримт системд шивүүлсэн. Мөн татварын цахим систем дэх татварын тооцооллын үлдэгдэл 113.0 сая төгрөгийн зөрүүтэй байсныг засварлуулсан.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

4.3 Албан шаардлага

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 30.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй урсгал засварын зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газар	3	148.2	2	118.1			1	30.1		